

## ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААН – Хуралдааны тойм

### ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААНААР ХЭЛЭЛЦСЭН АСУУДЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ № 23 (ТОЙМ)

Хуралдаан 2009 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн 14.30 цагт эхэлж, 17.10 цаг хүртэл Засгийн газрын Х1 байрын 301 тоот өрөөнд болж, нийт 2 цаг 40 минут үргэлжлэв.

№	Хэлэлцсэн асуудал	Гарсан шийдвэр
1	Гадаад харилцааны яамны газрын даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтанд дүгнэлт гарган, нэр дэвшүүлэх тухай	Гадаад харилцааны яамны Хөрш орнуудын газрын захирлын албан тушаалд Очирын Энхтөрийг томилуулахаар дүгнэлт гарган нэр дэвшүүлж Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Цогтбаатарт санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.
2	Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Стандартчилал, хэмжил зүйн газрын дэд даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтанд дүгнэлт гарган, нэр дэвшүүлэх тухай	Уг албан тушаалд нэр дэвшигчийн талаар тодруулах зүйл гарсан тул түүнийг нь тодруулаад дараагийн хуралдаанд танилцуулж шийдвэрлэхээр хойшлуулав.
3	Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны газрын даргын, Засгийн газрын тохируулагч агентлаг Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын болон Үндэсний хөгжил, шинэтгэлийн хорооны хэлтсийн даргын албан тушаалуудад тус тус томилогдох удирдах ажилтныг сонгон шалгаруулах тухай	Монгол Улсын Засгийн газрын тохируулагч агентлаг Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын, Засгийн газрын тохируулагч агентлаг Үндэсний хөгжил, шинэтгэлийн хорооны Шинэтгэлийн бодлогын газрын Хувийн хэвшил, инновацийн бодлогын хэлтсийн даргын, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны Шинжлэх ухаан, технологийн газрын даргын албан тушаалуудад тус тус томилогдох удирдах ажилтны сонгон шалгаруулалтыг 2009 оны 12 дугаар сарын 07-08-ны өдрүүдэд явуулахаар тогтож, зарлалыг нийтийн хэвлэлд тавихыг Ажлын албанд үүрэг болгов.
4	Засгийн газрын агентлагийн дарга нарын зөвлөхийн тухай	Засгийн газрын агентлагийн дарга нарын зөвлөхийн тухай асуудлыг авч хэлэлцэн зөрчлийг арилгаж хуульд нийцүүлэх нь зүйтэй гэж үзэн Засгийн газарт энэ тухай холбогдох санал хүргүүлэхээр тогтов.
5	Баянхонгор аймгийн Засаг даргын 2009 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн 18 дугаар захирамж (.аймгийн Газрын харилцаа, хот байгуулалтын газрын даргын албан тушаалд Д.Алтангэрэлийг томилсон тухай)-ийг хүчингүй болгох тухай	1.Баянхонгор аймгийн Засаг даргын 2009 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн 18 дугаар захирамжийн 2 болон 3, 4 дүгээр заалтыг хүчингүй болгох, 2.Төрийн албаны тухай хуулийн 39.6-д заасны дагуу энэхүү тогтоолыг биелүүлэх арга хэмжээ авахыг Баянхонгор аймгийн Засаг дарга Д.Амарсанаад зөвлөх тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.
6	Дорнод аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дарга М.Даваасамбуугаас гаргасан	1.Төрийн албаны тухай хуулийн 4.2.5, 26.1, 27.2.1 дэх заалтыг зөрчсөн байх тул И.Энхтуяад

	гомдлын талаар Маргаан хянан шалгах комиссын шийдвэрийн тухай	<p>төрийн албанд 1 жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр халах сахилгын шийтгэл ногдуулсан Дорнод аймгийн Мэргэжлийн хяналтын газрын даргын 2009 оны 6 дугаар сарын 26-ны өдрийн 44 дүгээр тушаалыг хууль зүйн үндэслэлгүй гэж үзэх,</p> <p>2.Дорнод аймгийн Мэргэжлийн хяналтын газрын даргын 2009 оны 6 дугаар сарын 26-ны өдрийн 44 дүгээр тушаалыг хүчингүй болгох,</p> <p>3.Ичинхорлоо овогтой Энхтуяаг Геологи, уул уурхайн хяналтын улсын байцаагчийн үүрэгт ажилд эгүүлэн томилохыг Дорнод аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дарга М.Даваа-самбууд үүрэг болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
7	”Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд тавигдах тусгай шаардлага”-ын тухай	Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд тавигдах тусгай шаардлагын талаарх хэлэлцэж буй төсөл дээрээ редакци хийгээд, дахин сайн ажиллаад Улсын Их Хуралд өргөн барих нь зүйтэй гэж үзэв.
8	Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцөд бүртгэх тухай	<p>1.2009 оны 5 дугаар сарын 02-03-ны өдрүүдэд Баян-Өлгий аймаг дахь Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлөөс зохион байгуулсан төрийн албаны мэргэшлийн шалгалтад Токтарханы Айдос 68.8, Бектемирийн Аниварсадат 71.3, Самарханы Аманкелд 67 оноогоор;</p> <p>2.Баянхонгор аймаг дахь Салбар зөвлөлөөс зохион байгуулсан мэргэшлийн шалгалтад Баатарсүрэнгийн Доржранжин 61.7 оноогоор тэнцсэн тул эдгээр нэр бүхий иргэдийг төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалтад бүртгэж, хавсралтын ёсоор батлах тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p> <p>3.Оргойн Буяннэмэх, Хүрэлбаатарын Алтанзагас нарыг төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалтад бүртгэх,</p> <p>4.О.Буяннэмэх, Х.Алтанзагас нарыг “Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц бүрдүүлэх журам”-ын нэгдүгээр хавсралтын дагуу бүртгэхийг төрийн жинхэнэ албаны нөөцийн асуудал хариуцсан ажилтанд үүрэг болгохоор шийдвэрлэв.</p>